



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

「 Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай 」

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 54,036,280.00 (тавин дөрвөн сая гучин зургаан мянга хоёр зуун наь) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн
.....167..... дугаар тогтоолын хавсралт



**"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт бүртгэх дүн (төгрөг)
1	Трансформатор	2024	3	ш	18,012,090.00	54,036,280.00
Нийт дүн						54,036,280.00
						(тавин дөрвөн сая гучин зургаан мянга хоёр зуун ная)